



УВС АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

Монгол Улсын Ерөнхий аудиторовн баталсан 2024 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөг
үндэслэн Төрийн аудитын тухай хуулиар тодорхойлсон бүрэн эрхийн хүрээнд
хийсэн гүйцэтгэлийн аудитын тайлан

Аудитын сэдэв:	“Хүүхэд хамгааллын талаар төрөөс баримталж буй бодлого түүний хэрэгжилт үр дүн”
Аудит хийсэн үндэслэл, бүрэн эрх	Аудитыг Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1-д заасан бүрэн эрхийн хүрээнд Улсын Их Хурлын Төсвийн Байнгын хорооны 2023 оны “Аудитын сэдэв батлах тухай” 08 дугаар тогтоол, Монгол Улсын Ерөнхий аудиторовн “Аудитын жилийн төлөвлөгөө батлах тухай” 2024 оны А/162 дугаар тушаалыг тус тус үндэслэн хийсэн.
Аудитын гол дүгнэлт:	Хүүхэд хамгааллын талаар төрөөс баримталж буй бодлого хэрэгжиж байгаа ч нийгэмд гарч буй үр нөлөөг тооцож үнэлэх аргачлал, мэдээллийн нэгдсэн сан байхгүй байна.

УВС АЙМАГ
2024 оны 10 дугаар сар

Аудитын зорилго, зорилт: Хүүхэд хамгааллын талаар төрөөс баримталж буй бодлого, түүний хэрэгжилт болон бий болсон үр дүнд гүйцэтгэлийн аудит хийж, дүгнэлт зөвлөмж боловсруулан Улсын Их Хурлын төсвийн байнгын хороо, холбогдох байгууллага, албан тушаалтанд танилцуулахад аудитын зорилго чиглэсэн.

Аудитын зорилгыг хангахын тулд дараах дэд зорилтын хүрээнд гүйцэтгэсэн. Үүнд:

- Хүүхэд хамгааллын талаар төрөөс баримталж буй бодлого, төлөвлөлтийн тогтолцоо оновчтой эсэх;
- Хүүхэд хамгааллын үйлчилгээний төлөвлөлт, төсөвлөлт үр өгөөжтэй, хүүхдэд ээлтэй байж чадсан эсэх;
- Хүүхэд хамгааллын талаар баримталж буй бодлогын хэрэгжилт үр дүнтэй эсэх;

Хүүхэд хамгааллын талаар төрөөс баримталж буй бодлого, тогтолцоо оновчтой байна.

Увс аймгийн Иргэдийн төлөөлөгчдийн хурлын тэргүүлэгчдийн 2018 оны 11 дүгээр сарын 23-ны өдрийн А/135 дугаар тогтоолоор “Хүүхдэд ээлтэй орон нутаг” дэд хөтөлбөрийг 2019-2020 онд хэрэгжүүлэхээр баталсан байна. Мөн 2021-2023 оны хувьд аймгийн Засаг даргын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөр, Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайдын 2022 оны 05 дугаар сарын 26-ны өдрийн А/110 дугаар тушаалаар Хүүхэд хамгааллын бодлогыг хэрэгжүүлэх үлгэрчилсэн зааврын хүрээнд аймгийн Хүүхэд, гэр бүлийн хөгжил, хамгааллын газрын жил бүрийн ажлын төлөвлөгөөг хөгжлийн бодлогод нийцүүлэн боловсруулан ажилласан байна.

“Хүүхдэд ээлтэй орон нутаг” дэд хөтөлбөрийг хэрэгжүүлэх ажлын хүрээнд хөтөлбөрийг хэрэгжүүлэх аргачлал, чадваржуулах сургалт, арга зүйн дэмжлэг үзүүлэх зорилгоор төр болон төрийн бус байгууллагуудын өргөтгөсөн уулзалт, хуралдааныг 4 үе шаттайгаар зохион байгуулж 17 байгууллагатай гэрээ байгуулан хамтран ажилласан байна.

Хүүхэд, гэр бүлийн хөгжил, хамгааллын газар нь 37 үзүүлэлтээр хүүхэд хамгааллын статистик тоо мэдээг цаасан хэлбэрээр гаргаж Хүүхэд, гэр бүлийн хөгжил, хамгааллын ерөнхий газарт хүргүүлж байна.

Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яамнаас нийгмийн үйлчилгээний чанар хүртээмжтэй байдлыг сайжруулах, нийгмийн ажилтнуудын өдөр тутмын ажлыг хөнгөвчлөх, бүртгэлийн мэдээллийг цахимжуулах зорилготой “Нийгмийн ажил үйлчилгээний нэгдсэн сан” мэдээллийн цахим системийг 2022 оны 01 дүгээр сард нэвтрүүлсэн байна. Энэ хүрээнд “namc.gov.mn” программд хамтарсан багийн нийгмийн ажилтан нь сум багийн иргэд болон өрхийн дэлгэрэнгүй мэдээллийг бүртгэх, өрхийн хүсэлтийг оновчтой шийдвэрлэх, кейс нээх, хаах, нөхцөл байдлын үнэлгээний мэдээллийг оруулж байсан байна. Харин “namc.gov.mn” программыг 2023 оны 10 дугаар сард бүрэн зогсоож нэвтрэх боломжгүй болгосон байна.

Хүүхэд хамгаалалд зориулсан төсөв, зардлыг судалгаанд үндэслэн тооцож төлөвлөөгүй, батлагдсан төсвийн хүрээнд хүүхэд хамгааллын үйл ажиллагааг зохион байгуулсан байна.

Хүүхэд, гэр бүлийн хөгжил, хамгааллын газрын бүтэц, орон тоог аймгийн Засаг даргын 2020 онд А/43, 2021 онд А/104 дүгээр захирамжаар тус тус баталсан байна. Харин 2022 онд босоо тогтолцоотой болж Засгийн газрын хэрэгжүүлэгч агентлаг Гэр бүл, хүүхэд, залуучуудын хөгжлийн газрын даргын А/65 дугаар

тушаалаар орон тоо, албан тушаалын нэршил, ангилал, зэрэглэл, дүрэм, бүтцийг баталсан байна.

Хохирогчийг түр хамгаалан байрлуулах үйлчилгээнд тавих нийтлэг шаардлага MNS 6040:2019 стандартын 11-д заасан “Түр хамгаалах байрны хүний нөөцөд тавих шаардлага”-ын дараах шаардлагуудыг хангаагүй байна. Үүнд:

- 11.7. Бүх ажилтныг хагас жил тутам эрүүл мэндийн урьдчилсан сэргийлэх үзлэг шинжилгээнд хамруулдаггүй
- 11.8. Ажилтан бүр гэмт хэрэгт холбогдож байгаагүйг цагдаагийн газрын тодорхойлолтоор нотолж чадахгүй
- 11.10. Ажилтан бүр түр хамгаалах байранд үйлчилгээ үзүүлэх ажилтны сургалтад хамрагдаж, гэрчилгээ аваагүй

Цаашид Хохирогчийг түр хамгаалан байрлуулах үйлчилгээнд тавих нийтлэг шаардлага MNS 6040:2019 стандартын 11 дэх заалтыг мөрдөж ажиллах зөвлөмж өглөө.

Төсвийн төлөвлөлт хийхдээ 2019-2022 онд хүүхэд хамгааллын чиглэлийн суурь судалгаа хийж, гарах зардлыг тооцож тусгаагүй байна. 2023 онд хүүхэд хамгааллын зардлыг өмнөх оны гүйцэтгэлд суурилан төсвийн төсөлд тусгасан байна.

Хүснэгт 12 /мян.төг/

№	Он	Батлагдсан төсөв	Гүйцэтгэл	Зөрүү	Хувь
1	2019	66,070.3	65,847.6	222.7	99.7
2	2020	107,447.7	106,859.4	588.3	99.5
3	2021	16,727.5	15,857.9	869.6	94.8
4	2022	115,676.3	112,195.3	3,481.0	97.0
5	2023	155,698.3	155,659.6	38.7	100.0

Эх сурвалж: Хүүхэд, гэр бүлийн хөгжил, хамгааллын газар

Хүүхэд, гэр бүлийн хөгжил, хамгааллын газар нь Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайдын 2020 оны А/150 дугаар тушаалаар баталсан “Түр хамгаалан байрлуулах үйлчилгээний нэг хүнд ногдох хувьсах зардал тооцох журам, Эрүүл мэндийн сайдын 2017 оны А/74 дүгээр тушаалын хавсралтаар баталсан жишгийн дагуу “0-18 насны хүүхдийн хувьд Эрүүл мэндийн сайд, Боловсрол, соёл, шинжлэх ухааны сайдын хамтарсан 2005 оны 225/296 дугаар тушаалын хавсралтаар баталсан жишгийн дагуу тус тус тооцно” гэж заасан байхад түр хамгаалах байраар үйлчлүүлсэн үйлчлүүлэгчийн насанд хүрэгчид болон 0-18 насны хүүхдийн нэг хоногт авах хоол хүнсний илчлэгийн хэмжээг тооцоогүй байна.

Цаашид түр хамгаалах байрны үйлчлүүлэгчдийн нас насны ангиллаар хоногт авах хоол хүнсний илчлэгийн хэмжээг тооцож, захиалгын хуудасны дагуу хүнсний материалыг олгож ажиллахыг зөвлөмж болгов.

Хүүхэд, гэр бүлийн хөгжил, хамгааллын газрын 2023 оны 12 дугаар сарын 28-ны өдрийн А/84 дүгээр тушаалаар 6 хамтарсан багт 2,154.3 мянган төгрөгийн санхүүжилт олгохоор шийдвэрлэсэн ч олгоогүй, 2023 оны санхүүгийн тайланд өглөгөөр тусгаагүй байна. Цаашид өр төлбөрийг санхүүгийн тайланд бүрэн тусгаж байхыг зөвлөмж болгов.

Хүүхэд хамгааллын бодлогын баримт бичгийн хэрэгжилт, үр дүн, нийгэмд гарч буй үр нөлөөг тооцож үнэлэх аргачлал байхгүй байна.

Аймгийн Засаг даргын 2023 оны 10 дугаар сарын 20-ны өдрийн А/608 дугаар захирамжаар “Аймгийн хүүхдийн төлөө зөвлөлийн дүрэм”-ийг шинэчлэн баталжээ. Сумдын хүүхдийн төлөө зөвлөлийн тайланг үнэлж дүгнэх талаар

аймгийн хүүхдийн төлөө зөвлөл нь дүрэмдээ тусгаж өгсөн боловч салбар бүрийн онцлогт нийцсэн шалгуур үзүүлэлт, нарийвчилсан аргачлал байхгүй байна.

Хөдөлмөрийн тухай хуулийн 43 дугаар зүйлийн 43.3 дахь хэсэгт “Ажилтны ажил, амралтын цагийг зохицуулах, амьдралын тэнцвэрийг хангахад дэмжлэг үзүүлэх, хөдөлмөрийн дотоод журамд тусгах замаар ажилтны хүүхдэд ээлтэй, хүүхэд хамгааллын бодлого хэрэгжүүлнэ” гэж заасан байна. Хүүхдийн төлөө үндэсний зөвлөлийн 2018 оны 03 дугаар тогтоолоор “Байгууллага, аж ахуйн нэгжийн дэргэд эцэг, эхийн зөвлөл байгуулж ажиллуулах зөвлөмж”-ийг баталсан.

Цаашид байгууллага, аж ахуй нэгжийн дэргэдэх эцэг эхийн зөвлөлийн үйл ажиллагааг идэвхжүүлэх чиглэл хүргүүлэх, сумдын хүүхдийн төлөө зөвлөлийн тайланг үнэлж дүгнэж ажиллахыг зөвлөмж болгов.

Аймгийн Боловсрол, шинжлэх ухааны газар 2019-2022 онд хүүхэд хамгааллын бодлогыг хэрэгжүүлэхдээ тусгайлан төлөвлөгөө, хөтөлбөр гаргаагүй ч, 2019, 2022, 2023 онуудад 29 ерөнхий боловсролын сургуулийн сурагчдын эрсдэлийн үнэлгээ, сургуулийн гадна, дотно орчны үнэлгээ хийсэн байна.

Увс аймгийн Эрүүл мэндийн газар нь 2019-2023 онд бэлгийн хүчирхийлэлд өртсөн 18 хүртэлх насны 37 хүүхдүүдийг эрүүл мэндийн үйлчилгээнд холбон зуучилж, шаардлагатай тохиолдлыг холбогдох байгууллагад шилжүүлэн ажилласан байна.

Харилцаа холбооны зохицуулах хорооны Увс аймаг дахь төлөөлөгч нь орон нутгийн 2 телевизийн үйл ажиллагаанд, хүүхдийн хөгжил, эрүүл мэнд, хүмүүжил, төлөвшилд сөрөг нөлөө үзүүлэхүйц мэдээ мэдээлэл, зар сурталчилгаа, тэмдэг, тэмдэглэгээ байршуулсан эсэхэд хяналт хийж ажилласан байна.

Онцгой байдлын газар Монгол Улсын Засгийн газрын 2017 оны 67 дугаар тогтоолоор баталсан “Гамшгийн аюулын тухай зарлан мэдээллийн дохио дамжуулах журам”-ын хүрээнд гамшиг ослын үед хүүхдийн эрхийг хамгаалах, тусламж үйлчилгээ хүргэх тусгай зориулалтын мэргэжлийн ангийн бэлэн байдлын үзлэгийг зохион байгуулж бэлтгэл бэлэн байдлыг хангуулан ажилласан байна.

Хүүхэд хамгааллын тогтолцоог бүхэлд нь хамарсан хүүхэд хамгааллын мэдээллийн удирдлагын систем байхгүй байна. Хүүхэд хамгааллын кейс тохиолдлыг шивдэг “namc.gov.mn” программ нь ажиллахгүй, able программд хурдан морь унаач хүүхдийн мэдээлэл оруулахаас өөр цэс байхгүй байна.

ЗӨВЛӨМЖ

Увс аймгийн Хүүхэд, гэр бүлийн хөгжил, хамгааллын газарт:

1. Хохирогчийг түр хамгаалан байрлуулах үйлчилгээнд тавих нийтлэг шаардлага MNS 6040:2019 стандартын 11 дэх заалтыг мөрдөж ажиллах.
2. Түр хамгаалах байрны үйлчлүүлэгчдийн нас насны ангиллаар хоногт авах хоол хүнсний илчлэгийн хэмжээг тооцож, захиалгын хуудасны дагуу хүнсний материалыг олгож ажиллах.
3. Өр төлбөрийг санхүүгийн тайланд бүрэн тусгах.
4. Байгууллага, аж ахуй нэгжийн дэргэдэх эцэг эхийн зөвлөлийн үйл ажиллагааг идэвхжүүлэх чиглэл хүргүүлэх, сумдын хүүхдийн төлөө зөвлөлийн тайланг үнэлж дүгнэж ажиллах.